



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№105 /105/

2021.08.04

УУЛЧИН ДАЙЧДАДАА ТАВАН ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ

МЭНДЧИЛГЭЭ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 331 ДҮГЭЭР АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА Ц.БУЯНТОГТОХ

Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө эрхэм үйлсэд хүчин зүтгэж, эрдэм ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулсан үе үеийн ахмад дайчид, одоо алба хашиж байгаа офицер, ахлагч, гэрээт цэрэг, ажилтан албан хаагчдаа анхны уулын цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 5 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2016 оны тушаалаар Зэвсэгт хүчний түүхэнд анхны "Уулын мэргэжлийн цэрэг"-ийн бие даасан анги болгож, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Уужмын хөндийд сууриа тавьж, голомтоо бадраан үүсэн байгуулагдсан билээ.

Тус ангийн бүтээн байгуулалт, сургалт бэлтгэл, бэлэн байдал, хуулиар хүлээсэн бусад үүргүүдэд залуу нас, хүч хөдөлмөрөө зориулж өвөг дээдсийнхээ халуун амь, бүлээн цусаараа гэрээслэн үлдээсэн Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах үндсэн үүргээ нэр төртэй биелүүлж, төр засаг, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин, ангийнхаа зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлэхээс гадна даян дэлхийн энхийг сахиулах, цэнхэр дуулгатны эгнээ, олон улсын

ажиллагаа, уулын хамтарсан сургалтуудад ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл хүчин зүтгэж, олон арван амжилт бүтээлээр дүүрэн түүхт 5 жилийн ойтойгоо учран золгож байна.

Ангийн маань өнгө төрх, амжилт бүтээл нь офицер, ахлагч, гэрээт цэрэг, ажилтан албан хаагчдын маань нөр их хүч хөдөлмөр, сэтгэл зүтгэлийн үр дүн бөгөөд ажил албандаа сэтгэл зүрхнээсээ бүтээлчээр хандаж ирсэн анхдагч нар та бүхнээрээ бахархаж байгаагаа энэ ташрамд илэрхийлэхэд таатай байна.

Тус ангийг өдий зэрэгт хөгжүүлэхэд БХЯ, ЗХЖШ, ХЗЦК, ТХЦК-ын удирдлага анхаарал хандуулан ирсэнд уулчин дайчдынхаа өмнөөс баярлаж, талархаж байгаагаа илэрхийлье.

Уулчин дайчид та бүхэндээ ангийн түүхт 5 жилийн ойг тохиолдуулан тус ангийн удирдлагууд, офицер, ахлагч, гэрээт цэрэг, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид тэдний гэр бүлд ойн баярын мэндийг дахин хүргэж, цаашдын ажил албанд тань арвин их амжилт, амьдралд тань эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай.

БИД ИЙН ЭХЭЛЖ БАЙЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны дугаар тогтоол, Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2016 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн... дугаар тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 331 дүгээр анги үүсэн байгуулагдсан түүхтэй.

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2016 оны 7 дугаар сарын 22, ХЗЦК-ийн 2016 оны 7 дугаар сарын 23, ангийн захирагчийн 2016 оны 7 сарын 24-ний өдрийн тушаалуудыг үндэслэн Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Ажиллагааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа О.Эрдэнэбаатар, тэргүүн ахлагч С.Одонбаяр, техникийн офицер, хошууч Ч.Банзрагч, авто техникийн шалгах албаны дарга, хурандаа Л.Баярцогт нараар ахлуулсан удирдлагын бүлэг, ангийн бүрэлдэхүүн 2016 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Улаанбаатар-

Арвайхээр-Баянхонгор-Говь-Алтай-Ховд-Баян-Өлгий аймгийн чиглэлд 1820 км-ийн маршийг осол зөрчилгүй үйлдэж Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн тусгай томилолтын уулын ротын үйл ажиллагаагаа явуулж байсан газар нутагт хүрэлцэн ирж барилга байгууламж, ашиглагдаж байсан авто болон хуягт техникүүдийг ангийн данс бүртгэлд хүлээн авснаар ангийн анхны суурь тавигдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Анги 2016 оны 7 дугаар сарын 29-ний өдөр Сагсай сумын Уужмын хөндий хэмээх газар ирснээр үйл ажиллагаагаа эхлүүлж өөрсдийн нөөц бололцоог ашиглан 17884 ширхэг блок үйлдвэрлэж, инженерийн торон саад бүхий 764 метр урт төмөр торон хашаа, тавиулангийн шалган нэвтрүүлэх байрыг барьж ашиглалтад оруулан мөн агуулах, албаны өрөө, хичээлийн танхимуудад засвар үйлчилгээ хийж сурч ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.



2017 оны 5 дугаар сарын 14-ний өдөр тус ангийн штаб, цэргийн гал тогоо, уурын зуух, шалган нэвтрүүлэх байр, гүний худгийн шав тавих ёслолын ажиллагаанд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн

командлагч бригадын генерал Б.Амгаланбаатар, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын даалгавар гүйцэтгэгч, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Д.Номт нарын албаны бусад хүмүүс оролцсон юм.

АНГИЙН УРИА
Дуудах нэр минь Уулын цэрэг
Дуурьсах алдар минь Уулчин дайчид
Дэлхийн дээвэр Оргилын эзэд
Дээдэс заяат Монгол цэрэг
Бид уулын тусгай батальоныхон



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
167.229 +1019	148.040 +2280	827 +4

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
4152 +74	213 +64	3862 +9

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 200,234,964
Эдгэрсэн	Нийт: 180,503,977
Нас барсан	Нийт: 4,258,448

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 16	☁️ 6
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	☁️ 20

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.0	2.851.0
EUR 🇪🇺	3.38.0	3.390.0
CNY 🇨🇳	441.0	442.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.70	26.24
KRW 🇰🇷	2.43	2.52

ЗУРХАЙ

2021.08.04 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН НАЙМАН ЦАГААН ХӨХ БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ
Наран ургах, шингэх:
05:33-20:24
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Авахүй
Суудал:
Гал

Өдрийн наран 5 цаг 33 минутад мандан, 20 цаг 24 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавиулах, угаал үйлдэх, бужиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэтгэж газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

ДЕЛЬТА ХУВИЛБАР

АНХЛААРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрх, нус гоожиж
- Булчин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавгүйрх, идэрх

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

УУЛЫН ТУСГАЙ БАТАЛЬОНД АЛБА ХААЖ БАЙГААГААРАА БАХАРХДАГ



Зэвсэгт хүчний отгон ангийн нэг болох уулын тусгай батальонд алба хаасан болон мөр зэрэгцэн алба хааж байгаа офицер, ахлагч, гэрээт цэрэг, ажилтан албан хаагч та бүхэнд ангийн түүхт 5 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Миний бие Зэвсэгт хүчинд 10 дахь жилдээ алба хааж байна. Анх 2011-2012 онд Ахлагчийн сургуулийг буудагч мэргэжлээр төгссөн. 2016 онд тус ангид тасгийн захирагчаар томилогдон ажлын гараагаа эхэлсэн. Одоо нэгдүгээр ротын өндрийн салааны ахлагч, тасгийн захирагчаар ажиллаж байна.

Ажиллах хугацаандаа анги хамт олны дэмжлэгээр БНӨСУ-ын НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагааны 8 дугаар ээлжид үүрэг гүйцэтгэсэн.

Зэвсэгт хүчинд алба хаах хугацаанд ангийн маань түүхт 5 жилийн ой тохиож буйд баяртай байна.

НЭГДҮГЭЭР РОТЫН ӨНДРИЙН САЛААНЫ АХЛАГЧ, ТАСГИЙН ЗАХИРАГЧ, АХЛАХ АХЛАГЧ И.БАТБААТАР

ТАВАН ЖИЛИЙН ХУГАЦААНД ОЛОН БҮТЭЭЛЧ АЖЛЫГ ХАМТРАН ХИЙСЭН



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги үүсэн байгуулагдсан цагаас хойш Баян-Өлгий аймгийн Сагсай сум өнгө төрх, үзэмжээ нэмж, цэрэг эрсийн гар бие оролцсон олон ажил, арга хэмжээнүүд өдөр ирэх бүр нэмэгдэж байгаад миний бие баяртай байдаг.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг иргэд олон нийтэд сурталчлах хүрээнд сургуулийн насны багачуудад эх оронч хүмүүжлийг олгох, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах зэрэг ажлаас гадна байгаль, цаг уурын хүнд үеүд болох цас зуд, үер усны гамшигын үед сумын иргэдэд дэмжлэг үзүүлэх, сумдад сүндэрлэж буй олон бүтээлч ажилд гар бие оролцож хамтарч ажилладагт үргэлж талархаж явдгаа үүгээр дамжуулан хэлэхэд таатай байна.

Бидний зүгээс өнгөрсөн хугацаанд тус ангийн полигоны бага бууны газар, 500 айлын орон сууц, 20 айл, туслах мал аж ахуйн өвөлжөө, хүнсний ногоо тариалалтын 1,9 га газар зэргийг шийдвэрлэн өгсөн бөгөөд цаашид ч хамтын ажиллагааны хүрээнд олон бүтээлч, үр дүнгээ өгсөн ажил арга хэмжээг хамтран зохион байгуулна гэдэгт итгэлтэй байна. Ингээд Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн хамт олон та бүхэнд ойн баярын мэндийг хүргэж ажлын амжилт, сайн сайхныг хүсье.

САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА А.ИСАТАЙ

ГЭРЭЛ ЗУРАГ НЭГ АГШИН



БИДНИЙ ОРОЛЦСОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД

2017 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар Алтай таван богд ууланд "Төрийн соёмбот хөшөө" босгох ажилд захирагч хурандаа Ц.Буянтогтохоор удирдуулсан бүрэлдэхүүнтэй оролцлоо.

2021-2025 онд ангийн бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд "500 айлын орон сууц", "20 айлын гэр хотхон", "30 айлын хашаа байшин" төсөл, хөтөлбөрүүдийг гарган баталгаажуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Сагсай сумын уужим 5 дугаар багт "500 айлын орон сууц төсөл"-ийн 5 га газрын 865 метр урт хашаа барих ажлыг өөрсдийн нөөц бололцоог ашиглан хийж гүйцэтгэсэн.

Ангийн малын суурийн өвөлжөөг 2017 оны 8 дугаар сард Сагсай сумын нутаг "Хөлцийт" хэмээх газар барьж байгуулав.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын дунд цэргийн алба, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх үндсэн зорилгын хүрээнд зохион байгуулагдсан Зэвсэгт хүчний Жанжин штабын "Цэргийн алба, сахилгын зөрчилгүй тэргүүний анги-2020" шалгаруулах болзолт уралдаанд

гутаар байрт шалгарав. Зэвсэгт хүчний 123 дугаар ангитай хамтарсан команд штабын хээрийн сургуулиудыг 2017, 2020 онд амжилттай зохион байгуулж оролцсон. Зэвсэгт хүчний марш тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тасаг, салааны тэмцээнд 2019 онд

ангиас анх удаа эрэгтэй салаа, эмэгтэй тасаг амжилттай оролцов. Зэвсэгт хүчний 2018 оны аварга шалгаруулах сагсан бөмбөг, гар болон хөл бөмбөгийн тэмцээнд ангийн баг тамирчид амжилттай оролцож гар бөмбөгийн тэмцээнд мөнгөн медаль хүртэв.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)